



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 5/105

Хэрлэн сум

О.Ган-Эрдэнийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Отгонтуяагийн Ган-Эрдэнийг Төрийн байгууллагын цахимжуулалт хариуцсан ажилтан Д.Должинсүрэнг ажилдаа эргэж орох хүртэл хугацаанд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс тус албан тушаалд томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ч.Баярцолмон	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Тэмүүжин	Нутгийн захиргааны бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн
	Т.Баяртуяа	Нярав

3.О.Ган-Эрдэний сарын үндсэн цалинг ТҮ-6 зэрэглэлээр тогтоон, 1,204,000 (нэг сая хоёр зуун дөрвөн мянган) төгрөгөөр тооцож, төрийн алба хаасан хугацааны

2.

нэмэгдлийг 3 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг О.Ган-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА